



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 11 өдөр

Дугаар А/446

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е" заалт, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2228, Их Монгол улс байгуулагдсаны 813, Ардын хувьсгалын 98 жилийн ойн баярыг тохиолдуулан Эх орон, ард түмнийхээ төлөө өргөсөн тангарагтаа үнэнч байж, албан үүргээ нэр төртэй гүйцэтгэн Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх үйлсэд хамт олноо манлайлан олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн Холбооны зангилгааны Р-140 радио станцын дарга, жолооч, ахлах ахлагч Э.Сүхбаатар, Хүнсний албаны сав угаагч Д.Ариунбилэг, тогооч, бэлтгэгч П.Тамир нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2.Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан Э.Сүхбаатар, Д.Ариунбилэг, П.Тамир нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч, хурандаа /М.Болдбаатар/-д зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/446 Ch  
02 02294